



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 05 сарын 28 өдөр

Дугаар А/314

Номгон

Хагас жилийн малын түүвэр
судалгаа явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.в, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан аймгийн "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хагас жилийн малын түүвэр судалгааг 2026 оны 06 дугаар сарын 04-10-ны өдрүүдэд зохион байгуулсугай.


2.Малын түүвэр судалгааны ажлыг зохион байгуулан явуулах комиссын бүрэлдэхүүнийг нэгдүгээр, хяналтын тооллогоор сумдад ажиллах хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Малын түүвэр судалгааны ажлын бэлтгэлийг сайтар хангаж хуулийн дагуу зохион байгуулалтын өндөр түвшинд явуулж, хяналтын тооллогыг чанартай гүйцэтгэн, цаг агаарын нөхцөл байдалтай уялдуулан аюулгүй байдлыг хангаж ажиллах, түүвэр судалгаанд сонгогдсон өрх нэг бүрээр цахим системд шивж нэгтгэлийг өрх, баг, сумын түвшингээр гарган аймгийн Статистикийн хэлтэст 2026 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн дотор ирүүлэхийг сумын Засаг дарга нарт, түүвэр судалгааг зохион байгуулахад шаардлагатай сургалт, заавар зөвлөмжийг өгч, аргачлал, маягтаар бүрэн хангаж ажиллахыг аймгийн Статистикийн хэлтэс (Г.Ганчимэг)-т үүрэг болгосугай.


4.Малын түүвэр судалгаанд хамрагдсан өрхийн мэдээлэлд тулгуурлан сумын түвшний нэгтгэл гарч, түүнд үндэслэн малын индексжүүлсэн даатгалд даатгуулсан малчдад нөхөн төлбөр олгодог тул мэдээллийг үнэн зөв цуглуулах,анхдагч мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангаж, системд шивэх явцад гарч болзошгүй алдаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тооллогын ажилд

хариуцлагатай хандахыг сумдын тооллогын комиссын дарга нарт, малын түүвэр судалгааны ажилд хариуцлагагүй хандсан албан тушаалтанд тухай бүрд нь хариуцлага тооцож, судалгааг хугацаанд нь зохион байгуулж дүн нэгтгэлийг Үндэсний Статистикийн Хороонд мэдээлэхийг аймгийн комисс (Б.Наранбаяр)-т даалгасугай.

5.Хагас жилийн малын түүвэр судалгааны зардал 2,000,000 (Хоёр сая) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (П.Отгонбаяр)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА  ЗӨНХБАТ

Аймгийн Засаг даргын орлогчны дугаар
сарын 2-ны өдрийн 478/14 дүгээр
захирамжийн 01 дүгээр хайсралт



МАЛЫН ТҮҮВЭР СУДАЛГАА ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын дарга

Б.Наранбаяр

Аймгийн Засаг даргын орлогч

Гишүүд

Т.Эрдэнэбат

Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

Г.Ганчимэг

Статистикийн хэлтсийн дарга

Сумдын Засаг дарга нар

Б.Саруул

Статистикийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга

Ч.Эрдэнэбат

Статистикийн хэлтсийн мэргэжилтэн

..... оОо.....

Аймгийн Засаг даргын 2086 оны 25 дугаар
сарын 28 ны өдрийн 1/314 дүгээр
захирамжийн 02 дугаар хавсралт

МАЛЫН ТҮҮВЭР СУДАЛГААНЫ ХЯНАЛТААР
СУМДАД АЖИЛЛАХ ХУВААРЬ

Б.Наранбаяр	Аймгийн Засаг даргын орлогч (Галуут, Жаргалант, Хүрээмарал сумд)
Т.Эрдэнэбат	Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (Баянцагаан, Баян-Өндөр, Шинэжинст сумд)
Г.Ганчимэг	Статистикийн хэлтсийн дарга (Баянхонгор сум, Эрдэнэцогт, Өлзийт сумд)
Б. Саруул	Статистикийн хэлтсийн ахлах мэргэжилтэн (Жинст, Баян-Овоо, Бууцагаан сумд)
Ч.Эрдэнэбат	Статистикийн хэлтсийн мэргэжилтэн (Богд, Баянговь, Баянлиг сумд)

.....оОо.....